

**АУДИТЫН ТАЙЛАН
2018**

**САНГУУДЫН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙГ АЙМАГ, СУМЫН ДУНД
ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГОТОЙ УЯЛДУУЛАН
ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

**АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН,
СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙН
ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН**

АУДИТЫН КОД: УАГ-НАГ/2018/02-НА-ХЭ

ТОВЧХОН

АГУУЛГА		
Аудитыг гүйцэтгэсэн:	ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
	АУДИТЫН ТАНИЛЦУУЛГА	3
Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар	АУДИТЫН ДҮН	5
	БҮЛЭГ 1: ОНХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй байна.	5
Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу бүрдүүлж, хуваарилсан боловч төлөвлөхөд баримтлах зарчмуудыг мөрдөөгүй байна. 	
Аудитын менежер Д.Оюунтуяа	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулахад баримтлах зарчмууд хэрэгжээгүй байна. 	
Ахлах аудитор Д.Эрдэнэбилэг	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, хэрэгжилтийг аймаг, сумын Засаг даргын зөвлөлөөр хэлэлцээгүй байна. ОНХС-ийн зааварт өөрчлөлт оруулах шаардлагатай 	
Аудитор Ц.Энхтүвшин	БҮЛЭГ 2: Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийг эргэн төлүүлэх талаар хангалтгүй ажиллажээ.	9
2018 он 11 сарын 28	<ul style="list-style-type: none"> Зарим сумд сум хөгжүүлэх сангийн орлогыг төлөвлөж, батлуулахгүйгээр төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна. Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулалт оновчтой хийгдэж чадахгүй байгаагаас зарим төсөл, хэрэгжихгүй, зориулалт бусаар зарцуулагдах шалтгаан болж байна. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг олон нийтэд тайлагнах, хяналт шалгалт хийх ажил хангалтгүй байгаагаас хугацаа хэтэрсэн зээлийн авлага үүсэх нөхцөл бүрдэж байна. 	
	Холбоо барих: Утас 7056-2112	БҮЛЭГ 3: Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.
Цахим хаяг khentii@audit.gov.mn	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад хийсэн 2017 онд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дунджаар 61,3%-тай байна. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн 2014-2017 оны үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлсэн боловч зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулаагүй байна. 	
Байршил	АУДИТЫН ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ	15
Хэнтий аймаг	Аудитын дүгнэлт	15
Хэрлэн сум	Аудитын зөвлөмж	15
Чингис хот	АУДИТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Аймгийн ЗДТГ-ын байр 320 тоот	Тайлангийн төсөлд ирүүлсэн санал ба тайлбар	16
	Тайланг баталгаажуулсан шийдвэр	20
	ХАВСРАЛТ	21

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР		
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	
АДБОУС	Аудитын Дээд байгууллагын Олон Улсын Стандарт	
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар	
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан	
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль	
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл	
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай	
ХБУлаан	Хэрлэнбаян-Улаан	
ЖДБДС	Жижиг дунд бизнесийг дэмжих сан	
СХС	Сум хөгжүүлэх сан	
ШТС	Шатахуун түгээх станц	
ШШГА	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр	

АУДИТЫН ТАНИЛЦУУЛГА

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2018 оны “Аудитын сэдэв батлах тухай” 03 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаалыг үндэслэн Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэх, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан тайланг УАГ-т хүргүүлж, аймгийн ИТХ, Засаг даргад танилцуулан, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлийн хүрээнд аудит хийлээ. Үүнд:

- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх;
- ❖ Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх;
- ❖ Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх.

Аудитад аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2017 оны орлого бүрдүүлэлт, төлөвлөгөө, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал, мөн сумдын сум хөгжүүлэх сангийн 2017 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагнал, хяналт, статистик мэдээ бусад баримт материалыг хамруулав.

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- МУ-ын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоол;
- МУ-ын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”.
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам

Аудитыг гүйцэтгэхэд аудитын удирдамж АДБОУС 100, 400, 3000, 3100-ийг ашиглан Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар, сумын Засаг даргын Тамгын газар болон холбогдох бусад албан тушаалтантай ярилцах, иргэдээс санал асуулга авах, судалгаа авч дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ТАЛААР

Хэнтий аймгийн 2017 оны ОНХС-д өмнөх оны үлдэгдэл 551.6 сая төгрөг, ОНХНС-аас олгосон 1625.2 сая төгрөгийн шилжүүлэг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болсон 130.0 сая төгрөг, хандив тусламж, олон улсын байгууллагын төслөөс 392.0 сая төгрөг, зарлагыг хэмнэх замаар бий болсон 171.4 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 19.3 сая төгрөг, нийт 2893.9 сая төгрөг төвлөрчээ.

Хэнтий аймгийн хэмжээнд 2017 онд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 2904.0 сая төгрөгийн 175 төсөл, арга хэмжээг төлөвлөж, аймаг, сумын ИТХ-аар баталуулсан байна. Үүнээс 316.0 сая төгрөгийн 13 арга хэмжээ нь 2016 онд хийгдсэн боловч санхүүжилт нь дутуу олгогдсон ажил байна.

Аймгийн ОНХС-аас санхүүжүүлэх “2017, 2018 онд хийгдэх ажлуудын зураг, төсөл” нь 6, “Хөтөлбөр, төсөл, арга хэмжээ” нь 7 арга хэмжээ болж задарч хэрэгжсэн байна.

2017 онд 1650.8 сая төгрөгийн 121 арга хэмжээний худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг ТБОНӨХБАУХА тухай хуулийн 7.1¹-д заасан тендер шалгаруулалтын журмын дагуу зохион байгуулж, 1427.5 сая төгрөгийн 152 гэрээ байгуулжээ.

Аймаг, сумын ОНХС-ийн санхүүжилтээр 2017 онд нийт 2697.1 сая төгрөгийн 178 төсөл, арга хэмжээ, үүний дотор өмнөх оны санхүүжилт дутуу 14 арга хэмжээний 347.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, шинээр 2349.3 сая төгрөгийн 164 арга хэмжээг хэрэгжүүлэн, гүйцэтгэгч шалгараагүйн улмаас 9 арга хэмжээг хэрэгжүүлж чадаагүй байна.

Аймаг, сумын ИТХ-ийн дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, дотоод хяналтын алба ОНХС-аас санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлжээ.

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ТАЛААР

Хэнтий аймгийн сумдын сум хөгжүүлэх сангийн 2017 оны эх үүсвэрийг 1841,6 сая төгрөгийн эх үүсвэрийг батлуулснаас жилийн эцсийн гүйцэтгэлээр 1267,1 сая төгрөг төвлөрсөн нь төлөвлөгөөг 574,5 сая төгрөгөөр дутуу буюу 68,8 хувийн биелэлттэй байна

Аймгийн хэмжээнд сум хөгжүүлэх сангаас олгогдсон зээл 2016 оны жилийн эцэст 661 иргэн, аж ахуйн нэгжийн 4596,3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол 2017 оны жилийн эцэст 679 зээлдэгчийн 4564.2 сая төгрөгийн зээлийг авлагаар бүртгэгдсэнээс Галшар, Баянмөнх, Биндэр, Баян-Овоо, Бор-Өндөр сумын иргэн, аж ахуйн нэгжээс авах 28.8 сая төгрөгийн авлагыг дутуу тусгажээ.

Сумдын сум хөгжүүлэх сангаас 2017 онд 99 төсөлд 672.0 сая төгрөгийн зээл олгосны 62 төсөл, арга хэмжээ сангийн журамд нийцсэн үйлдвэрлэлийн чиглэлд олгосон бол 39 төсөл арга хэмжээ нь үйлдвэрлэлийн бус төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх, малжуулах чиглэлийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлжээ.

¹ 7.1.Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна:

7.1.1.нээлттэй тендер шалгаруулалтын журам;

7.1.2.тендер шалгаруулалтын онцгой журам;

7.1.3.зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам.

7.1.4.олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам.

Сум хөгжүүлэх сангийн зээлтэй иргэдээс 2017 онд 333 иргэн 727.8 сая төгрөгийн үндсэн зээл, 187 иргэн 37.4 сая төгрөгийн хүү нийтдээ 762,0 сая төгрөгийг барагдуулснаас 76 иргэн 225,7 сая төгрөгийн зээлийг төлж зээлийн төлбөрөө дуусгасан байна.

Хэнтий аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар сум хөгжүүлэх сангаас зээл авч үйл ажиллагаа явуулж байгаа 760 иргэн, аж ахуйн нэгжээс 4141,4 сая төгрөгийн 470 төсөл, арга хэмжээ нь жижиг дунд үйлдвэрлэл эрхэлж ажлын байр бий болгох, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулах чиглэлээр, 2654,2 сая төгрөгийн 290 төсөл, арга хэмжээ нь малжуулах, бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх, худалдаа болон хөрөнгө бий болгох чиглэлээр олгогджээ

Хэнтий аймгийн хэмжээнд Бор-Өндөр сумаас бусад 17 сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас сум хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөлийг шинэчлэн байгуулсан боловч хяналтын зөвлөл нь улирал тутам хийгдэх хяналт шалгалтыг хийгээгүй байна.

АУДИТЫН ДҮН

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ОНХС-ИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА.

А.1 ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ БҮРДҮҮЛЖ, ХУВААРИЛСАН БОЛОВЧ ТӨЛӨВЛӨХӨД БАРИМТЛАХ ЗАРЧМУУДЫГ МӨРДӨӨГҮЙ БАЙНА.



Аймгийн хэмжээнд 2017 онд ОНХС-д нийт 2893.9 сая төгрөг төвлөрсөн нь “Төсвийн тухай” хуулийн 60.2² дахь заалттай нийцэж байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч ОНХС-аас олгосон 1625.2 сая төгрөгийн шилжүүлгийг дараах байдлаар хуваарилсан нь “Төсвийн тухай” хуулийн 59.2³ дахь заалттай нийцэж байна.

² 60.2.Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

60.2.1.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг;

60.2.2.энэ хуулийн 59.2-т заасан хөрөнгө;

60.2.4.татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;

60.2.5.тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг.

60.2.6.Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 10 хувь;

60.2.7.ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь.

³ 59.2.Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна:


59.2.1.энэ хуулийн 60.11-д заасан үйлчилгээний зардалд ногдох хэсгийг сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэх;

59.2.2.энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах;

59.2.3.улсын төсвөөс аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд энэ хуулийн 60.2.6, 60.2.7-д заасан орлогын шилжүүлгийг 60 дугаар зүйлийн 60.6, 60.7-д заасан хувь хэмжээгээр хуваарилах.

59.2.4.энэ хуулийн 59.1.3, 60.2.5-д заасан эх үүсвэрийг хандивлагч талаас болон урамшуулал, дэмжлэг олгогч байгууллагаас хүлээн авагч талыг тусгайлан заасан тохиолдолд тухайн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилах ба итгэлцүүрээр хуваарилах хөрөнгөд тооцохгүй.

Сумдын ОНХС-д олгох шилжүүлгийг “Төсвийн тухай” хуулийн 59.2 дахь заалтын дагуу “Хүн амын тоо”, “Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ” итгэлцүүрийг үндэслэн тооцож хуваарилсан боловч “Орон нутгийн хөгжлийн индекс”, “Орон нутгийн татварын идэвх санаачилга итгэлцүүрийг ашиглаагүй байна.



ОНХС-ийн нэр	59.3.1. Орон нутгийн хөгжлийн индекс	59.3.2. Хүн амын тоо	59.3.3. Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ			59.3.4. Орон нутгийн татварын идэвх санаачилга	Итгэлцүүрт үндэслэн хуваарилалтын дүн
			Хүн амын нягтрал	Аймгийн төвөөс алслалт	Нутаг дэвсгэрийн хэмжээ		
Галшар		3.59		5.22	7.66		16.48
Баянхутаг		3.67		0.86	6.92		11.44
Баянмөнх		2.76		3.90	2.93		9.59
Дархан		3.12		5.65	4.95		13.73
Дэлгэрхаан		3.97		4.87	4.58		13.42
Жаргалтхаан		3.55		3.90	3.16		10.61
Цэнхэрмандал		3.14		5.65	3.65		12.44
Өмнөдэлгэр		9.38		4.68	12.48		26.54
Батширээт		3.82		7.64	8.06		19.52
Биндэр		6.75		7.17	6.16		20.09
Баян-Адрага		4.11		6.28	3.47		13.85
Дадал		4.79		10.53	5.43		20.75
Норовлин		3.98		7.80	6.12		17.90
Батноров		9.20		4.09	5.67		18.96
Баян-Овоо		2.81		5.26	3.88		11.96
Бор-Өндөр		14.57		7.60	0.17		22.34
Мөрөн		3.11		1.05	2.52		6.69
Хэрлэн		36.56		0.00	4.37		40.93
ДҮН	0.00	122.89	0	92.17	92.17	0	307.23

Засгийн газрын 2014 оны 242 дугаар тогтоолоор “Сумын хөгжлийн индекс тооцох аргачлал” батлагдсан боловч өнөөг хүртэл тооцоогүй нь тус тогтоолын 4 дүгээр заалт⁴-ыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой юм.

⁴ 4. Сумын хөгжлийн индекс тооцоход шаардлагатай мэдээллийг тогтоолын 2 дугаар хавсралтад тусгагдсан байгууллагуудаар гаргуулан сум бүрээр нэгтгэн боловсруулж тухайн жилийн I улиралд багтаан Эдийн засгийн хөгжлийн яаманд албан бичгээр хүргүүлж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нар болон бүх шатны Засаг дарга нарт даалгасгай.

Монгол Улсын Засгийн газар, “Олон улсын хөгжлийн ассоциаци” хооронд байгуулсан гэрээний дагуу хэрэгжиж байгаа “Тогтвортой амьжиргаа-3” төслийн “Сайн засаглал-үр дүнд суурилсан урамшууллын хөтөлбөр”-ийн хүрээнд олгосон 370.2 сая.төг-ийн урамшууллыг нэр заасан сумдад бүрэн олгосон байна. Мэдээллийг <http://tusuv-oronnutag.mof.gov.mn/?p=156>-аас авав.



Хэнтий аймгийн хэмжээнд 2017 онд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 2904.0 сая төгрөгийн 175 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, сумын ИТХ-аар баталсан байна. Үүнээс 316.0 сая төгрөгийн 13 арга хэмжээ нь 2016 онд хийгдсэн боловч санхүүжилт дутуу олгогдсон ажил байна.

Батлагдсан нийт хөтөлбөр, төсөл, арга хэмжээний 159 нь буюу 90.9% нь “Төсвийн тухай” хуулийн 58.2⁵, 58.4⁶ заалттай нийцэж байна. Харин 16 хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь “Төсвийн тухай” хуулийн аймаг, сум өөрийн төсвөөр тухайн шатанд бие даан хэрэгжүүлэх чиг үүрэгтэй нийцэхгүй байна.

Тухайлбал “Өндөрхаан нисэх буудал”, “Аймгийн Цагдаагийн барилга”, согтолт хэмжих болон торгуулийн багаж нь орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө биш, урьдчилан сэргийлэх үзлэг, зорилтод бүлгийнхэнд цахим үнэмлэх, өндөр настанд хивээ, тэжээл авч өгөх нь халамжийн байгууллагаас, аймгийн өсвөрийн шигшээ багийн дасгалжуулагчийн цалин, хүүхдийн цэцэрлэгийн ор, хөнжлийн даавуу зэргийг тухайн байгууллагын төсвөөс санхүүжүүлэх зардлууд байна.

Иймд аймаг, сумын ОНХС-аас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг “ОНХС-ийн заавар”-т нийцсэн эсэхэд аймаг, сумын Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг дүгнэлт гаргаж тухайн шатны ИТХ-аар батлуулдаг байх шаардлагатай.

Нийт 1308.2 сая төгрөгийн 88 арга хэмжээ нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7.2⁷, 7.4⁸-д заасан

⁵ 58.2. Аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ:

⁶ 58.4. Сум өөрийн төсвөөр дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ:

⁷ 7.2. Аймаг ОНХС-ийн хөрөнгөөр “Төсвийн тухай” хуулийн 58.2 заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлж болно.

⁸ 7.2. Сум ОНХС-ийн хөрөнгөөр “Төсвийн тухай” хуулийн 58.4-т заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлж болно.

хэрэгжүүлэх боломжтой чиг үүргүүдтэй нийцэж байна. Гэвч аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн байна.

Тухайлбал Баян-Овоо, Баянхутаг, Бэрх, Галшар сумын гудамж талбайн камержуулалт нь “ОНХС-ийн заавар”-ын 7.2.10, Батширээт сумын “Соёл, спортын цогцолбор”, Баян-Адрага сумын “Инженерийн шугам сүлжээ”, Галшар сумын “Багийн тохижилт”, Дархан сумын “Нэгдсэн халаалт”, Өлзийт тосгоны “Захирагчийн ажлын албаны барилгын их засвар”, Хэрлэнбаян Улаан тосгоны “Цэцэрлэгийн барилгын их засвар” зэрэг арга хэмжээнүүд “ОНХС-ийн заавар”-ын 7.2.2-т хамаарч байгаа тул аймгийн ОНХС-аас санхүүжүүлэхээр байсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг төлөвлөхөд баримтлах зарчмын хэрэгжилтийг авч үзвэл:

1. Нийт 303.5 сая төгрөгийн 44 арга хэмжээ аймаг, сумын дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдаагүй нь “ОНХС-ийн заавар”-ын 4.1 дэх зарчимтай нийцэхгүй байна.
 - a. *Аймаг, сумын дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдаагүй дээрх арга хэмжээнүүдийн 34.0% нь “Үндэсний баяр наадам”, 11.4% нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, 11.4% нь золбин нохой, шумуул устгал зэрэг жил бүр зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.*
 - b. *Харин бусад арга хэмжээнүүд нь багийн ИНХ-д оролцогчид өндөр хувьтай дэмжсэн арга хэмжээнүүд байна.*
2. Нийт 159.7 сая төгрөгийн 23 арга хэмжээ нь орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдээгүй ч эрэмбэлэгдсэн жагсаалтад орсон нь “ОНХС-ийн заавар”-ын 4.2 дэх зарчимтай нийцэхгүй байна.
 - a. *Баян-Овоо сум 4, Баянхутаг сум 9, Бор-Өндөр 2, Батширээт, Баянмөнх, Дэлгэрхаан, Мөрөн, Норовлин, Өмнөдэлгэр сумууд, Өлзийт, Хурх тосгон тус бүр 1 арга хэмжээг иргэдийн саналаар дэмжигдээгүй байхад эрэмбэлсэн жагсаалтад оруулж баталсан байна.*
3. Нийт 1421.8 сая төгрөгийн 67 төсөл, арга хэмжээ ТЭЗҮ, зураг төсөвгүйгээр аймаг, сумын ИТХ-аар батлагдсан нь “ОНХС-ийн заавар”-ын 4.7 дэх зарчимтай нийцэхгүй байна.
 - a. *Аймгийн ОНХС-аас санхүүжүүлэх “2017, 2018 онд хийгдэх ажлуудын зураг, төсөв”, “Хөтөлбөр, төсөл, арга хэмжээ”-ний хүрээнд ямар арга хэмжээ хэрэгжүүлэх нь тодорхойгүйгээр баталжээ. Тухайлбал 22.0-294.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй аймгийн ОНХС-аас санхүүжүүлэх “2017, 2018 онд хийгдэх ажлууд”, “Хөтөлбөр, төсөл, арга хэмжээ”-ний хүрээнд ямар арга хэмжээнүүд хэрэгжих нь тодорхойгүй, “Хэрлэн сумын 2-р багийн төв”, Баян-Адрага сумын “Сумын төвийн инженерийн шугам”, Биндэр сумын “Хурхын голын гүүр”, Бор-Өндөр сумын “Усны машин”, “Зам засвар”, Галшар сумын “Ахмадын байрны засвар”, Дархан сумын “ЕБС-ийн ариун цэврийн өрөө”, Жаргалтхаан “Хог тээврийн машин”, “Хог түрэх машин”, Хэрлэн сумын “Бэлчээрийн менежмент хийх, хуучин уст цэгийг засварлах” гэх мэт арга хэмжээнүүдийн зураг, төсөв, техникийн тодорхойлолт бэлэн болоогүй байжээ.*
 - b. *ОНХС-аас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг, төсөв, тооцоо судалгааг “ажил эхлэхийн өмнө бэлэн байлгахад хангалттай” гэсэн нийтлэг ойлголттой байна.*
4. Нийт 57.5 сая төгрөгийн 2 арга хэмжээний санхүүжилт өөр бусад эх үүсвэртэй давхардсан нь “ОНХС-ийн заавар”-ын 4.8 дахь зарчимтай нийцэхгүй байна.
 - a. *Баян-Адрага сумын инженерийн шугам сүлжээ ажлын өртөг 130.0 сая төгрөг ба аймгийн орон нутгийн төсвөөс 100.0 сая төгрөг зарцуулсан байна.*
 - b. *Дархан сумын ЕБС-ийн ариун цэврийн өрөөний өртөг 85.0 сая төгрөг ба Мобиком, Дэлхийн зөн”-өөс 54.5 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.*

Сангийн сайдын өгсөн чиглэлийн дагуу аймгийн ХХААГ-ын мал эмнэлгийн үйлчилгээний зардлыг 100.0%, “Өндөрхаан” хот тохижилтын газрын зардлын 23.5%, “Бор-өндөр” хот тохижилтын газрын зардлын 41.3%-ийг буюу нийт 601.1 сая төгрөгийн суурь зардлыг ОНХС-аас санхүүжүүлсэн байна.

А.2 ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХАД БАРИМТЛАХ ЗАРЧМУУД ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

ОНХС-аас 2017 онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн нийт 187 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Шилэн дансанд байршуулсан эсэхийг авч үзвэл 14 арга хэмжээг өмнөх онд, шинээр хийгдсэн 83 арга хэмжээг 2017 онд байршуулсан байна. Мөн аймаг, сумын ОНХС-ийн төсөв, гүйцэтгэлийг шилэн дансанд бүрэн байршуулжээ.

Харин мал эмнэлгийн үйлчилгээний болон хот тохижилтын зардал болон 2017 онд шинээр хэрэгжих 86 арга хэмжээг шилэн данс дахь худалдан авах төлөвлөгөөнд тусгаагүй байна.

ОНХС-аас 2017 онд санхүүжүүлэхээр шинээр төлөвлөсөн суурь зардлаас бусад 170 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Сангийн яамны худалдан авах ажиллагааны цахим системд бүртгэгдсэн эсэхийг авч үзвэл Tender.gov.mn-д 114 арга хэмжээ бүртгэгдсэн байна.

Өмнөх оны татварын орлогын давсан хэсэг, иргэд байгууллагын хандив зэргээр эх үүсвэр нэмэгдэж, 2017 оны 5 дугаар сард хийсэн тодотголоор 55 арга хэмжээг нэмж хэрэгжүүлэхээр сумдын ИТХ баталсан боловч цахим мэдээллийн системд бүртгэх боломжгүй байсан байна. Энэ нь ОНХС-ийн эх үүсвэр, зайлшгүй хэрэгцээгээ тодорхойлж чадаагүйгээс шалтгаалсан байна.



байгуулжээ.

ОНХС-аас 2017 онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн 9 арга хэмжээ нь “худалдан авах ажиллагаанд оролцогч бүртгэгдээгүй” шалтгаанаар цуцлагдсан ба 121 арга хэмжээний худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг ТБОНӨХБАУХА тухай хуулийн 7.1⁹-д заасан тендер шалгаруулалтын журмын дагуу зохион байгуулж, 1427.5 сая төгрөгийн 152 ажил гүйцэтгэх гэрээ

Энэ онд нийт 316.5 сая төгрөгийн 39 арга хэмжээг худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр хэрэгжүүлсэн байна. Үүний дотор “Үндэсний их баяр наадам”-ын морь, бөх, сурын шагналаас бусад 155.3 сая төгрөгийн зардал багтаж байна. Бусад 17 арга хэмжээний хувьд үнийн дүнгээр авч үзвэл 34.8 сая төгрөгийн 13 арга хэмжээ нь шууд худалдан авч болох, 126.4 сая төгрөгийн 4 арга хэмжээний худалдан авах ажиллагааг тендер шалгаруулалтын онцгой журмын дагуу зохион байгуулах ажил үйлчилгээ байна.

⁹ 7.1.Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна:

7.1.1.нээлттэй тендер шалгаруулалтын журам;
 7.1.2.тендер шалгаруулалтын онцгой журам;
 7.1.3.зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам.
 7.1.4.олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам.

Харин 126.5 сая төгрөгийн 4 арга хэмжээг худалдан авах ажиллагааны журам зөрчин зохион байгуулжээ.

Дархан сумын ЕБС-ийн ариун цэврийн өрөөний 27.5 сая төгрөгийн санхүүжилтийг 3 талын гэрээгээр, “Өсвөрийн шигшээ баг”, “Урьдчилан сэргийлэх үзлэг”, “Хөтөлбөрүүдийн нээлт” зэрэг арга хэмжээний 99.0 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн байна.

ОНХС-ийн зааврын 8.3-д заасан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-ын дагуу зохион байгуулсан худалдан авах ажиллагаа байхгүй байна.

ОНХС-аас 2017 онд нийт 178 арга хэмжээнд 2697.1 сая төгрөгийг зарцуулсны 177 арга хэмжээний 2670.6 сая төгрөг аймаг, сумын ИТХ-аар батлагдсан, Баянхутаг сумын “Жишиг сум хөтөлбөрт хамрагдах гишүүнчлэлийн төлбөр”-т олгосон 26.6 сая төгрөг нь батлагдаагүй зардал байна.

Баянхутаг сумын ОНХС-аас иргэдийн санал аваагүй, сумын ИТХ-аар батлагдаагүй “Жишиг сум хөтөлбөрт хамрагдах гишүүнчлэлийн төлбөр” нэрээр 26.6 сая төгрөгийг тодорхой бус дансанд шилжүүлсэн нь залилан, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй байна.

Сангийн сайдын “Орон нутгийн 2017 оны төсөв боловсруулж, батлуулахад анхаарах зүйлс”-ээр өгсөн чиглэлийн дагуу суурь зардлын 601.1 сая төгрөгийн 3 арга хэмжээг шууд санхүүжүүлсэн

Өмнөх онд худалдан авах ажиллагаа нь зохион байгуулагдаж, хэрэгжсэн боловч санхүүжилт нь дутуу олгогдсон 14 арга хэмжээний 347.9 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгожээ.

ОНХС-ийн санхүүжилтээр 2017 онд шинээр бий болсон 421.0 сая төгрөгийн 40 хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэж, Хэрлэн сумын “Гудамжны хонхор тэгшлэх”, Баян-Овоо сумын “Цагдаагийн байрны халаалт”, Бор-Өндөр сумын “Зам засвар”, Дадал сумын “Бирваз”, Мөрөн сумын “Ногооны талбайн шуудууны засвар”, Хэрлэн сумын “Гудамжны тэмдэг, тэмдэглэгээ” гэх мэт нийт 412.4 сая төгрөгийн 22 хөрөнгийг бүртгээгүй байна.

ОНХС-аас санхүүжүүлсэн “Өндөрхаан нисэх буудал”, “Аймгийн Цагдаагийн газрын барилга”, Дархан сумын “Нэгдсэн халаалтын зураг төсөв” зэрэг нийт 302.5 сая төгрөгийн 16 зураг, төсвийн ажил хийгдсэн боловч төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааварт хаана бүртгэх нь тодорхойгүй байна.

2017 онд хэрэгжсэн 2 арга хэмжээнд гэрээгээр гүйцэтгэх ажил дуусаагүйгээс 43.1 сая төгрөг, 1 арга хэмжээнд өмнөх оны дутуу санхүүжилт 16.0 сая төгрөг, 9 арга хэмжээнд гарсан зардлын зөрүү болох 9.9 сая төгрөг, нийт 12 арга хэмжээнд 69.0 сая төгрөгийг гэрээний дүнгээс дутуу олгосон байна.

Батноров сумын ОНХС-аас санхүүжүүлсэн “Бэрх хотын доторх замын засвар”-ын ажлыг 2017 оны 11-12 дугаар сард гүйцэтгэхээр гэрээ байгуулж, 2.0 сая төгрөгийг шилжүүлэн авсан боловч дараа оны 4 дүгээр сард хийж гүйцэтгэсэн байна.

Баянхутаг сумын ОНХС-аас “Ахуйн үйлчилгээний халаалт” анхан шатны баримтгүйгээр 5.0 сая төгрөгөөр илүү, “Хүүхдийн цэцэрлэгийн хашаа”-ны санхүүжилтийг батлагдсан төсвийн дүнгээр шилжүүлж, гэрээний дүнгээс нийт 5.9 сая төгрөгөөр илүү санхүүжүүлсэн байна.

2017 онд нийт 2697.1 сая төгрөгийг 178 төсөл, арга хэмжээнд зарцуулсныг “ОНХС-ийн заавар”-т заасан баримтлах зарчмыг хэрхэн хангасныг шалгахад дараах зөрчил илэрч байна.

1. “Төсвийн тухай” хуулийн 60.3.6 дахь заалтыг зөрчин нийт 37 арга хэмжээнд 577.7 сая төгрөг зарцуулсан нь “ОНХС-ийн заавар”-ын 4.3 дахь зарчимтай нийцэхгүй байна.
 - a. *Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх боломжгүй 224.7 сая төгрөгийн 2*
 - b. *Орон нутгийн иргэдээс санал аваагүй 353.0 сая төгрөгийн 35 арга хэмжээ байна.*
2. Нийт 39 арга хэмжээнд 212.6 сая төгрөгийг удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулсан нь “ОНХС-ийн заавар”-ын 4.4 дахь зарчимтай нийцэхгүй байна. Үүнд:
 - a. *Үндэсний баяр наадмын зардлын 78.6 сая төгрөг Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолтой зөрчилдөж байна.*
 - b. *Тусгай шилжүүлгийн байгууллага хүүхдийн цэцэрлэг, биеийн тамир спорт, эрүүл мэндийн үйлчилгээг дэмжиж 82.4 сая төгрөгийн 4*
 - c. *Орон нутгийн төсвийн байгууллагыг дэмжиж 6.4 сая төгрөгийн 1*
 - d. *Харин 45.2 сая төгрөгийн 12 арга хэмжээ нь нийтийн эрх ашигт чиглэгдээгүй арга хэмжээнүүд байна. Үүнд архины хамаарал бүхий иргэдэд зориулсан сургалт, сумын хилийн самбар босгох, леки, хөтөлбөрүүдийн нээлт зэрэг арга хэмжээнүүд зохион байгуулсан байна.*
3. Нийт 8 арга хэмжээнд 244.5 сая төгрөг зарцуулсан нь “ОНХС-ийн заавар”-ын 4.5 дахь зарчимтай нийцэхгүй байна.
 - a. *Улсын төсвөөс санхүүждэг “Өндөрхаан” нисэх буудал, Цагдаагийн газрын барилгын зураг төсөвт 224.7 сая төгрөг, 6 сумын цагдаад 19.4 сая төгрөгийн согтолтыг хэмжих болон торгуулийн багаж авч өгчээ.*
4. Нийт 6 арга хэмжээнд 23.6 сая төгрөгийг буцалтгүй тусламж, дэмжлэгт зарцуулсан нь “ОНХС-ийн заавар”-ын 4.6 дахь зарчимтай нийцэхгүй байна.
 - a. *Бор-Өндөр сумын зорилтод бүлгийн иргэдийг цахим үнэмлэхтэй болгоход 3.3 сая төгрөг, аймгийн болон Дархан сумын иргэдийн эрүүл мэндийн оношилгоо, шинжилгээний зардалд 18.8 сая төгрөг, Өлзийт тосгоны өндөр настанд хивэг авч өгөхөд 0.4 сая төгрөгийг ОНХС-аас зарцуулсан ба Хэрлэн сумын ОНХС-аас 1.0 сая төгрөгийг Өлзийт тосгоны 45 жилийн ойн арга хэмжээнд зориулан хандивласан байна.*

А.3 "ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ, ХЭРЭГЖИЛТИЙГ АЙМАГ, СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛӨӨР ХЭЛЭЛЦЭЭГҮЙ БАЙНА.

ОНХС-аас санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд хийсэн хяналт шинжилгээ ба үнэлгээний талаар

1. Аймаг, сумын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороод ОНХС-ийн санхүүжилтээр 2017 онд хэрэгжсэн 168 арга хэмжээний төлөвлөлтөд, 165 арга хэмжээний санхүүжилтэд, 147 арга хэмжээний гүйцэтгэлийн явцад хяналт хийгээгүй байгаа нь “ОНХС-ийн заавар”-ын 9.1 заалттай нийцэхгүй байна.
2. Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба ОНХС-аас санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд гүйцэтгэлийн болон санхүүгийн хяналт шалгалтыг 2017 онд зохион байгуулаагүй нь “ОНХС-ийн заавар”-ын 9.2 заалттай нийцэхгүй байна.
3. Аймгийн ЗДТГ аймаг, сумын ОНХС-ийн хэрэгжилтийг санхүүгийн болон бусад хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтээр мэдээллийн сан байгуулах, холбогдох мэдээллээр баяжуулах ажлыг хангалтгүй зохион байгуулсан нь “ОНХС-ийн заавар”-ын 9.5 дахь заалттай нийцэхгүй байна. Харин аймгийн ЗДТГ-ын санхүү, төрийн сангийн хэлтэс сумдын ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэлийг хянаж сургалт, зөвлөгөө өгсөн нь үр дүнтэй ажил болжээ.
4. Аймаг, сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар ОНХС-ийн санхүүжилтээр 2017 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үр дүнг хэлэлцээгүй нь “ОНХС-ийн заавар”-ын 9.6 дахь заалттай нийцэхгүй байна.

ОНХС-аас санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний үр дүнг тайлагнасан талаар

1. ОНХС-ийн зааврын 10.1-д зааснаар сумын ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг аймгийн Засаг даргад танилцуулаагүй байна.
 - а. Өмнөх аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар аймгийн ЗДТГ-аас 2017 онд 2 удаа сумын Засаг дарга нарт 2 удаа албан бичиг хүргүүлсэн боловч сумын ОНХС-ийн хэрэгжилтийн явцын тайлангаа ирүүлээгүй тухай аймгийн ЗДТГ-ын 2018 оны 5/1908 дугаар албан бичгээр тайлбар ирүүлсэн.

А4."ОНХС-ИЙН ЗААВАР"-Т ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ.

“Төсвийн тухай” хуулийн 58.2, 58.4-т хамаарах Мал эмнэлгийн үйлчилгээний зардал, орон нутгийн өмч шинээр бий болгох, засварлах, хог цэвэрлэгээ, зайлуулах, мал амьтны халдварт шимэгчтэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, Үндэсний баяр наадмын зардал гаргах зэрэг нийт 146.1 сая төгрөгийн 59 арга хэмжээ нь зааварт тусгагдаагүй байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний зардал, орон нутгийн өмч шинээр бий болгох, засварлах, хог цэвэрлэгээ, зайлуулах, амьтны халдварт шимэгчтэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, зэрэг арга хэмжээнүүдийг “Төсвийн тухай” хуулийн 60.11¹⁰-д зааснаар, Үндэсний их баяр наадмын зардлыг 60.3.2-т зааснаар ОНХС-аас санхүүжүүлж болох боловч “ОНХС-ийн заавар”-т тодорхой тусгаж өгөөгүй, мөн “ОНХС-ийн заавар”-ын 7.2.3, 7.4.2-т заасан “Малжуулах” арга хэмжээ нь “Төсвийн тухай” хуулийн 58.2, 58.4-т заасан чиг үүрэгт байхгүй зэрэг эрх зүйн баримтууд зөрчилдөж байна.

¹⁰ 60.11.Энэ хуулийн 60.3.6 дахь заалтад 58.1.8, 58.1.12, 58.2.11, 58.2.12, 58.2.15, 58.3.4, 58.4.3, 58.4.4, 58.4.9, 58.4.10-т заасныг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйлчилгээний зардал хамаарахгүй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ОЛГОСОН ЗЭЭЛИЙГ ЭРГЭН ТӨЛҮҮЛЭХ ТАЛААР ХАНГАЛТГҮЙ АЖИЛЛАЖЭЭ

Б.1. ЗАРИМ СУМД СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ОРЛОГЫГ ТӨЛӨВЛӨЖ , БАТЛУУЛАХГҮЙГЭЭР ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ САНХҮҮЖҮҮЛСЭН БАЙНА.

Хэнтий аймгийн сумдын СХС-ийн 2017 оны орлогод сангийн өмнөх оны үлдэгдлээс 460,0 сая төгрөг, үндсэн зээлийн эргэн төлөлтөөс 1329,8 сая төгрөг, зээлийн хүүний эргэн төлөлтөөс 51,8 сая төгрөг нийт 1841,6 сая төгрөгийн эх үүсвэрийг сумын ИТХ-аар батлуулсан байна.

Харин Биндэр сум 2017 оны сум хөгжүүлэх сангийн орлогын эх үүсвэрийг батлаагүй байгаа нь Төсвийн тухай¹¹ хууль болон “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”¹²-ыг зөрчсөн байна.

СХС-ийн эх үүсвэрт 2017 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 1267,1 сая төгрөг төвлөрсөн нь төлөвлөгөөнөөс 574,5 сая төгрөгөөр дутуу буюу 68,8 хувийн биелэлттэй байна.



Нийт орлогын 460,0 сая төгрөг нь сангийн өмнөх оны үлдэгдлээс, 727,8 сая төгрөг нь үндсэн төлбөрийн эргэн төлөлтөөс, 37,5 сая төгрөг нь хүүгийн төлбөрөөс, 41,8 сая төгрөг нь хугацаа хэтэрсний алдангиас тус тус бүрдсэн байна

СХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө Галшар, Баянмөнх, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Баян-Адрага, Батноров, Мөрөн сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөд зөвхөн үндсэн зээлээс 261,4 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөж, хүүгийн орлогыг төлөвлөж батлуулаагүй байна.

Мөн Галшар, Батноров, Бор-Өндөр сумд хүүгийн орлогыг батлуулаагүй боловч 2.0 сая төгрөгийг зарцуулсан нь “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”¹³-ыг мөрдөөгүй байна.

Журамд заасны дагуу сангийн эх үүсвэрт улс орон нутгийн төсвөөс, гадаад дотоод иргэнээс, хандив тусламж болон бусад эх үүсвэрээс хөрөнгө төвлөрүүлэхээр төлөвлөөгүй бөгөөд зээл, зээлийн хүүгийн орлогоос бусад эх үүсвэрээс хөрөнгө төвлөрөөгүй байна.

¹¹ 64.1.2 “Тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах,”

¹² 3.3 “Сангийн үйл ажиллагааны талаар сумын ИТХ дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ” 3.3.1 “Сангийн төсвийг баталж...”

¹³ 3.5.7 “Сангаас олгосон зээлийн хүүгийн тухайн жилийн орлогыг зарцуулах саналыг энэ журмын 1.8-д заасны дагуу боловсруулж, жил бүрийн сумын төсөвтэй хамт иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулна.

Аймгийн хэмжээнд СХС-аас олгогдсон зээл 2016 оны жилийн эцэст 4596,3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 661 иргэн, аж ахуйн нэгжийн 4493.0 сая төгрөг нь үндсэн зээл, 333 иргэн, аж ахуйн нэгжийн 103.4 сая төгрөг нь хүүгийн үлдэгдэл байна.

Төлөгдөөгүй зээлийг ангилбал 28 төсөл, арга хэмжээний 146,9 сая төгрөгийн зээл хэвийн төлөгдөж байгаа бол 206 төсөл, арга хэмжээний 1181,3 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, 427 төсөл, арга хэмжээний 3268,2 сая төгрөгийн чанаргүй зээл эзэлж байна.

Дээрх хөнгөлөлттэй, хүү багатай, үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн 119 зээлдэгчид 2017 онд 41.8 сая төгрөгийн алдангийг нэмж тооцсон бол бусад хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлд нэмж алданги тооцоогүй байна.

СХС-аас 2017 онд 99 төсөлд 672.0 сая төгрөгийн зээл олгосны 62 төсөл, арга хэмжээ сангийн журамд нийцсэн үйлдвэрлэлийн чиглэлд олгосон бол 39 төсөл арга хэмжээ нь үйлдвэрлэлийн бус төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх, малжуулах чиглэлийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн ба нийт 33.5 сая төгрөгийн хүү тооцсон байна.

СХС-ийн зээлтэй иргэдээс 2017 онд 333 иргэн 727.8 сая төгрөгийн үндсэн зээл, 187 иргэн 37.4 сая төгрөгийн хүү нийтдээ 762,0 сая төгрөгийг барагдуулснаас 76 иргэн 225,7 сая төгрөгийн зээлийг төлж зээлийн төлбөрөө дуусгасан байна.

Мөн сангийн зээлийг эргэн төлөхдөө Дархан, Норовлин сумд СХС-ийн 2 зээлдэгч 0.8 сая төгрөгийн эргэн төлөлтийг ЖДБДС-нд, Дархан, Өмнөдэлгэр, Норовлин, Хэрлэн, Бор-Өндөр сумын бусад санд зээлтэй 15 иргэн 8.9 сая төгрөгийг тус сангийн дансанд төвлөрүүлсэн байна.



Сангаас олгосон зээлийн авлагын үлдэгдэл 2017 оны жилийн эцэст 679 зээлдэгчийн 4564.2 сая төгрөг байгаагийн 112 зээлдэгчийн 736.7 сая төгрөгийн зээл графикт хугацаанд төлөгдөж байгаа хэвийн зээл бол нийт зээлийн 83,9%-ийг хугацаа хэтэрсэн зээл эзэлж байгаагаас 182 зээлдэгчийн 980,5 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, 387 зээлдэгчийн 2847.1 сая төгрөгийн чанаргүй зээл байна.

Б.2. СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ОНОВЧТОЙ ХИЙГДЭЖ ЧАДАХГҮЙ БАЙГААГААС ЗАРИМ ТӨСӨЛ, ХЭРЭГЖИХГҮЙ, ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛАГДАХ ШАЛТГААН БОЛЖ БАЙНА.

Хэнтий аймгийн 18 суманд жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр 294 иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа явуулж байгаагаас гурил, гурилан бүтээгдэхүүний 68, оёмол, нэхмэл бүтээгдэхүүний 52, сүү, сүүн бүтээгдэхүүний 46, модон эдлэлийн 31, эрчимжсэн мал аж ахуйн 21, мах, махан бүтээгдэхүүний 14, барилгын материалын 13, хэвлэлийн эх бэлтгэлийн 13, ноос, ноолууран эдлэлийн 10, арьс ширэн эдлэлийн 6, бусад чиглэлийн 18 үйлдвэрлэл байна.

Жижиг дунд үйлдвэрлэлийг сумдаар нь авч үзвэл Хэрлэн суманд 81 ЖДҮ, Жаргалтхаан, Биндэр, Бор-Өндөр, сумдад тус бүр 21-29 ЖДҮ, Цэнхэрмандал, Батширээт, Баян-Адрага, Дадал, Батноров, Баян-Овоо сумдад тус бүр 14-19 ЖДҮ, Бусад сумдад тус бүр 1-9 ЖДҮ явагдаж байгаа ба Гурванбаян, Өлзийт, ХБУлаан тосгонд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байхгүй байна.



Хэнтий аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар Сум хөгжүүлэх сангаас зээл авч үйл ажиллагаа явуулж байгаа 760 иргэн, аж ахуйн нэгжээс 4141,4 сая төгрөгийн 470 төсөл, арга хэмжээ нь сум хөгжүүлэх сангийн журамд нийцсэн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэж ажлын байр бий болгох, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулах чиглэлээр олгогджээ.

Харин СХС-ийн төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь тус сангаас олгогдох зээлийг журамд нийцүүлэн олгох талаар хангалтгүй ажилласнаас 2654,2 сая төгрөгийн 290 төсөл, арга хэмжээ нь малжуулах, бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх, худалдаа болон хөрөнгө бий болгох чиглэлээр олгогдсон зээл байна.

СХС-ийн журамд нийцээгүй¹⁴ автозасвар, худалдаа, барилга болон ахуйн үйлчилгээний чиглэлийн 205 төсөл, арга хэмжээнд 1863.4 сая төгрөг, малжуулах, худаг ус, зоорь зэрэг хөдөө аж ахуйн чиглэлийн 53 төсөлд 423.0 сая төгрөг, бусад бэлэг дурсгал, ШТС, мал эмнэлэг, сантехникийн зэрэг зориулалтаар 32 төсөлд 367.8 сая төгрөг нийт 290 төсөлд 2654.2 сая төгрөгийг олгосон байна.

Тус сангаас 2017 оны байдлаар зээлийн үлдэгдэлтэй 760 төсөл, арга хэмжээний зээлийн болон барьцааны гэрээг бүрэн байгуулж, баталгаажуулсан боловч гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байгаагаас зээлийг зориулалтын дагуу ашиглахгүй байх, зээлийн эргэн төлөлт хангалтгүй, хугацаа хэтэрсэн зээлийг шуурхай барагдуулах ажил хийгдэхгүй байна.

СХС-аас олгосон зээлийн хугацаа хэтрэлтэд алданги тооцохоор гэрээнд тусгасан боловч 21 сум, тосгоны Засаг даргын Тамгын газар 569 зээлдэгчийн 3827.5 сая төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэлд гэрээний дагуу алданги тооцоогүй байна. Мөн Баян-Овоо сум 73,0 сая төгрөгийн 3 төслийг СХС-ийн журамд¹⁵ заасан сумын Засаг даргын шийдвэргүйгээр зээл олгосон байна. Үүнд:

- Иргэн Ш.Мөнхбатын “ШТС байгуулах төсөлд 40,0 сая төгрөг,
- Иргэн Б.Оюунболорын “Арвижих” талх, нарийн боовны цех төсөлд 10,0 сая төгрөг,
- Иргэн С.Наранбаатарын Универсал трактор авахад 23,0 сая төгрөгийг олгожээ.

¹⁴ Сангийн хөрөнгийг сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах, үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулна.

¹⁵ 3.5.2 “Энэ журамд заасны дагуу зээл олгох шийдвэр гаргах”



Аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар СХС-аас хөнгөлөлттэй зээл авч үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа тус сангийн журамд нийцсэн 470 төсөл арга хэмжээг 4141.5 сая төгрөгөөр санхүүжүүлж нийтдээ 775 ажлын байр, сангийн журамд нийцээгүй төрөл бүрийн үйлчилгээ, малжуулах, барилгын үйлчилгээ болон бусад чиглэлийн 290 төсөл арга хэмжээг 2654.2 сая төгрөгөөр санхүүжүүлж 415 ажлын байрыг нийтдээ

аймгийн хэмжээнд 1190 ажлын байрыг хадгалах буюу шинээр бий болгосон дүн мэдээ байна.

Б.3. СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ АЖИЛ ХАНГАЛТГҮЙ БАЙГААГААС ХУГАЦАА ХЭТЭРСЭН ЗЭЭЛИЙН АВЛАГА ҮҮСЭХ НӨХЦӨЛ БҮРДЭЖ БАЙНА.

Бор-Өндөр сумаас бусад 17 сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас СХС-ийн хяналтын зөвлөлийг шинэчлэн байгуулж, тус хяналтын зөвлөл нь эргэн төлөлт хангалтгүй болон найдваргүй зэрэг хугацаа хэтэрсэн зээлдэгчдийн зээлийг эргэн төлүүлэх талаар авах арга хэмжээний талаар 2017 онд хуралдсан боловч түүний хэрэгжилтийг хангах талаар ажиллаагүй байна.

Тус хяналтын зөвлөл СХС-аас хөнгөлөлттэй зээл авсан иргэн, аж ахуйн нэгжүүд сангийн зээлийг зориулалтын дагуу ашиглаж ажлын байр бий болгон үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд улирал тутам хийгдэх хяналт шалгалтыг хийгээгүй, дүнг сумын иргэдэд мэдээлэх, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх зэрэг ажлыг зохион байгуулаагүй байна.

Биндэр сумын СХС-ийн хяналтын зөвлөл 2017 онд тус сангаас санхүүжилт авсан зээлдэгчдийн үйл ажиллагаа, хугацаа хэтэрсэн зээлийг эргэн төлүүлэх талаар хяналт шалгалтын ажил хийгээгүй байна.

СХС-аас олгосон зээл болон хүүгийн үлдэгдэл 4564,2 сая төгрөгийн авлагыг 2017 оны санхүүгийн тайланд бүртгэснээс Галшар, Баянмөнх, Биндэр, Баян-Овоо, Бор-Өндөр сумын иргэн, аж ахуйн нэгжээс авах 28.8 сая төгрөгийн авлагыг дутуу тусгасан байна.

СХС-ийн авлагыг Галшар сум 2,4 сая төгрөг, Баянмөнх сум 11,7 сая төгрөг, Биндэр сум 0,6 сая төгрөг, Баян-Овоо сум 0,6 сая төгрөг, Бор-Өндөр сум 13,5 сая төгрөгөөр дутуу тусгасан нь зээлийн мэргэжилтэн нягтлан бодогч нар зээл, хүүгийн үлдэгдлийн талаарх хоорондын тооцоог тулган баталгаажуулаагүйг харуулж байна.

СХС-аас хөнгөлөлттэй зээл авсан иргэдээс 2016 оны жилийн эцсийн байдлаар 658 төсөл, арга хэмжээний 4596.3 сая төгрөгийн зээл, хүүгийн төлбөр төлөгдөөгүй байгаагаас хугацаа хэтэрсэн зээлтэй 13 иргэн 54,0 сая төгрөгийг график гарган төлж байгаа бол зээлдэгч нас барсан, зээлээ төлөхөөс татгалзсан, хаяг тодорхойгүй шилжсэн, шүүхэд өгөхөөр материал бүрдүүлсэн болон бусад шалтгаанаар 344 зээлдэгчийн 2067,7 сая төгрөгийг төлүүлэх талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна.

Дээрх чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлээс 881,5 сая төгрөгийн 131 зээлдэгчийг шүүхэд шилжүүлэн зээл төлүүлэх эвлэрлийн гэрээ байгуулсан бол 824.4 сая төгрөгийн 79 зээлдэгчийн зээлийг эргэн төлүүлэх шүүхийн шийдвэр гаргуулан ШШГА-нд шилжүүлэн албадан төлүүлж байна.

СХС-ийн хяналтын зөвлөл журамд заасны дагуу сангийн зээлийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн, эргэн төлөлтөд хяналт шалгалт хийгдээгүй тул журамд нийцээгүй төсөл, арга хэмжээнд санхүүжилт олгох, олгосон зээлийг зориулалт бусаар зарцуулсан иргэн, аж ахуйн нэгжид хариуцлага тооцох ажил хийгдээгүй байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ӨМНӨХ ОНЫ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

В.1 Орон нутгийн хөгжлийн сангийн 2017 оны зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дунджаар 61.3%-тай байна.

Өмнөх аудитын дүнд үндэслэн аймгийн Аудитын газрын 2017 оны 90-107 дугаар албан бичгээр сумын Засаг дарга нарт өгсөн зөвлөмж 83.2%, аудитын тайлангаар аймгийн Засаг даргад өгсөн зөвлөмж 42.9%-тай хэрэгжсэн байна.

ТЭЗҮ, зураг төсөвгүй арга хэмжээг ИТХ-аар батлуулдаг зөрчлийг Батноров, Баян-Адрага, Баянхутаг, Бор-Өндөр, Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал сумд давтан гаргажээ.

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага 59.3%-тай хэрэгжсэн байна.

- a) ОНХС-аас санхүүжүүлсэн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй зөрчлийг арилгах албан шаардлагыг Хурх тосгон, худалдан авах ажиллагааны журам зөрчсөн зөрчлийг арилгах албан шаардлагыг Өмнөдэлгэр сум 100.0% хэрэгжүүлжээ.
- b) ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг Дархан сум, иргэдийн саналаар дэмжигдээгүй арга хэмжээг эрэмбэлсэн жагсаалтад оруулдаг зөрчлийг Батширээт, Баян-Адрага, Баянмөнх, Бор-Өндөр, Галшар, Дэлгэрхаан, Жаргалтхаан сумд давтан гаргаж сумын зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна

2016 онд ажлын гүйцэтгэлгүй санхүүжүүлсэн 31.5 сая төгрөгийг сумын ОНХС-д буцаан төвлөрүүлэх акт хуулийн байгууллагад шалгагдаж, гарсан шийдвэрийн дагуу ажлыг 2017 онд хийж гүйцэтгэсэн байна.

В.2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлсэн боловч зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулаагүй байна.

Хэнтий аймгийн хэмжээнд СХС-ийн хөрөнгийн 2014-2016 оны үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүнд тус сангийн үйл ажиллагаа, орлого зарлагын гүйцэтгэлд жил бүр аудит хийлгэж дүнг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэх, санд хийх дотоод хяналт шалгалтыг сайжруулж, холбогдох албан тушаалтан, байгууллагуудыг үнэн зөв мэдээллээр хангах, сангийн хөрөнгийг эргэн төвлөрүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах тухай аудитын Зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлсэн боловч Зөвлөмжийг хэрэгжүүлсэн талаар Төрийн аудитын байгууллагад хариу ирүүлээгүй байна.

Мөн СХС-ийн зарцуулалтад 2017 онд хийсэн аудитаар 27.2 сая төгрөгийн хөрөнгийг сумын ЗДТГ-ын өмчид бүртгэх, 5.4 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгах, найдваргүй 44 зээлдэгчийн зээлийг албадан төлүүлэх, хугацаа хэтэрсэн 49 зээлдэгчтэй гэрээ байгуулан зээл төлүүлэх ажлыг зохион байгуулах ажлыг 2017 онд хийж гүйцэтгэх албан шаардлагыг Хэрлэн сумын Засаг даргад өгснийг бүрэн хэрэгжүүлсэн талаар 2018 оны 10 сарын 29-ны 1/612 тоот албан бичгээр аймаг дахь Төрийн аудитын хариу ирүүлсэн.

ИРГЭДЭЭС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ЕРӨНХИЙ ДҮН**А. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙХ ШААРДЛАГАТАЙ АЖЛЫН САНАЛ АВАХ АЖИЛД ИРГЭДИЙН ОРОЛЦОО ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

Хэнтий аймаг 76019 хүн амтай, судалгаанд 513 хүн буюу нийт хүн амын 0.7% нь оролцлоо. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн дундаж нас 37, 54.2% нь дээд, 11.8% нь дунд, 34.1% нь бага боловсролтой байна.

ОНХС-ийн талаар 52.8% нь хангалтгүй мэдээлж байна гэж үзсэн бол мэдээлэлтэй иргэдийн 45.6% нь Засаг даргаас, 18.8% нь мэдээллийн самбараас, 6.2% нь иргэний танхимаар, 29.4% нь нутгийн иргэдээс мэдээлэл авдаг гэж хариулжээ.

Судалгаанд оролцогчдын 62.7% нь ОНХС-тай холбоотой хууль, тогтоомж, журам, зааврыг судлаагүй байна.

Багийн Засаг даргын 2017 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийх шаардлагатай ажлын саналыг иргэдээс авдаг гэж 59.4% нь үзсэн бол, 29.1 хувь нь “мэдэхгүй” гэж хариулжээ. Судалгаанд оролцогчдын 83.0% нь ОНХС-ийн хөрөнгөөр хийх шаардлагатай ажлын санал авах ажилд оролцоогүй байна.

Засаг дарга иргэдээс авсан саналыг эрэмбэлж, хамгийн их санал авсан ажлуудыг иргэдэд танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг хийгээгүй гэж 47.0% хариулсан бол “сайн мэдэхгүй” гэж 21.6% нь хариулсан байна. Нээлттэй хэлэлцүүлэгт судалгаанд оролцогчдын 66.8% нь оролцоогүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлууд бодиттой хэрэгжээгүй гэж 66.8% нь үзсэн бол “сэтгэл хангалуун биш” гэж, 41.6% нь, “мэдэхгүй” гэж 14.5% нь хариулжээ.

Ач холбогдолтой гэж үзэх давхардсан тоогоор 60 санал гаргасан байна. Саналын 31.7% нь суманд хуваарилагдсан ОНХС-ийн хөрөнгө бага байна, 23.3% нь ОНХС-ийн талаарх мэдээллийг сурталчлах ажил дутмаг, 10.0% нь бүтээн байгуулалтын чиглэлээр зориулах, 8.3 хувь нь хөрөнгийн зарцуулалт ил тод биш, 6.7% нь иргэдийн саналыг илүү ихээр тусгах, 3.3% нь саналын эрэмбэлэлт, чанартай гүйцэтгэхэд анхаарах нь зүйтэй гэсэн санал ирүүлжээ. Бусад саналын хувьд ОНХС-аас санхүүжүүлж болох ажлуудыг хэрэгжүүлэхийг санал болгосон байна.

Б. СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧИД ХАНГАЛТТАЙ МЭДЭЭЛЭЛГҮЙ БАЙНА.

СХС-ийн үйл ажиллагааны талаар 22 сум тосгоны ЖДҮ эрхлэгч болон үйлчилгээ эрхлэгч 245 иргэнийг хамруулсан санал асуулга авсан болно.

Нийт хамрагдсан иргэдийн 25% нь жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, 75% нь худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэд байлаа.

Санал асуулгад оролцогчдын 55% нь сангийн зээлийг үр дүнтэй, 18% нь дунд зэрэг гэж үнэлсэн бол 10% нь үр дүнгүй, 12% нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Хэнтий аймгийн хэмжээнд Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 294 иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа явуулж байна.

д/д	Сумдын нэр	ЖДҮ-ийн төрөл /тоо/
-----	------------	---------------------

		Нийт	Гурил, гурилан бүтээгдэхүүн	Мах, махан бүтээгдэхүүн	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Ус, Ундаа	Ноос ноолууран бүтээгдэхүүн	Оёмол, нөхмөл бүтээгдэхүүн	Мод, модон бүтээгдэхүүн	Эм, био бэлдмэл	Барилгын материал	Эрчимжсэн мал аж ахуй	Арьс ширэн бүтээгдэхүүн	Хэвлэл эх бэлтгэл	Байгалийн гаралтай	Бусад
1	Галшар	5	2		2						1					
2	Баянхутаг	5		1			1	2	1							
3	Баянмөнх	7	1		2			1				1	2			
4	Дархан	6	1	1	1			2	1							
5	Дэлгэрхаан	6	1				1	2	1		1					
6	Жаргалтхаан	25	3		5		2	3	4		2	1	2	1	2	
7	Цэнхэрмандал	14	3		4			5	1					1		
8	Өмнөдэлгэр	5			1				2					2		
9	Батширээт	19	7		3				6			3				
10	Биндэр	21	10		3			2	2		1	2		1		
11	Баян-Адарга	14	4		2		1	2	2			1	1	1		
12	Дадал	16	8	3	3				2							
13	Норовлин	9	4		2		1		2							
14	Батноров	16	4		6			3	2			1				
15	Баян-Овоо	15	2		1		1	3	1			5				2
16	Мөрөн	1			1											
17	Хэрлэн	81	15	6	8	1	3	20	3	3	6	3	1	5		7
18	Бор-Өндөр	29	3	3	2			7	1	1	2	4		2		4
19	Бэрх	0														
20	Гурванбаян	0														
21	Өлзийт	0														
22	ХБУлаан	0														
	ДҮН	294	68	14	46	1	10	52	31	4	13	21	6	13	2	13

Санал асуулгад оролцсон иргэдийн 65% нь СХС-ийн талаар мэдээлэлтэй, 56% нь сангаас зээлд хамрагдсан болон сангийн үйл ажиллагааг иргэдийн 55% нь сайн гэж үнэлсэн байна.

СХС-ийн мэдээллийг баг, сумын Засаг даргаас 44% нь авдаг бол 27% нь нутгийн иргэдээс, 22% нь хэвлэл мэдээллээс авсан байна.

Сумдын иргэдийн 35% нь мэдээлэлгүй, 44% нь тус сангийн зээлд хамрагдаж байгаагүй бол санал асуулгад оролцогчдын 56% нь сангийн журмыг судлаагүй байна.

Сангийн үйл ажиллагааг иргэдийн 21% нь хангалтгүй гэж үнэлсэн бол 29% нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Тус аймгийн Мөрөн сум, Гурванбаян, Өлзийт, ХБУлаан тосгонд үйлдвэрлэл хөгжөөгүй бол жижиг, дунд үйлдвэрлэлтэй сумын СХС-аас олгосон хөнгөлөлттэй, үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийн зээлд тавих хяналт хангалтгүй байгаагаас олгогдсон зээл нь жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх бус төрөл бүрийн үйлчилгээ болон малжуулах чиглэлд зарцуулсан байдал нийтлэг байна.

Санал асуулгад оролцогч иргэдийн 37% нь зээлийг танил талаараа, 11% нь намчирхдаг, 11% нь зээлийг хасаж өгдөг, 16% нь хүсэлт хүлээн авдаггүй гэсэн бол 26% нь бусад шалтгааныг дурдсан байна.

Жишээлбэл: Бизнесийн чиглэлтэй зээлийн чиглэл тохирдоггүй, мэдээлэл өгдөггүйгээс дандаа хоцордог, өмнөх зээл авсан хүмүүс зээлээ төлөөгүйгээс, яг юм

хийж байгаа хүнээ дэмждэггүй, урд нь хүсэлт өгсөн хүмүүс хамрагдаагүй тул өгдөггүй зэрэг хүндрэл бэрхшээлийг дурдсан байна.

Зээл олгогдсон хүмүүс зээлийн үр дүнгийн талаар худлаа төсөл бичсэн хүмүүс зээл авдаг, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр үр дүнгүй, зээлийг зориулалтын дагуу зарцуулдаггүй, зээлийг танаж хэт олонд хүнд өгдгөөс үр дүн багатай зэрэг саналаа илэрхийлсэн байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

А. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ТАЛААР

1. ОНХС-ийн хөрөнгөөр хийх төсөл, арга хэмжээг эрэмбэлэхдээ зааварт заасан баримтлах зарчмуудыг мөрдөөгүй байна.
2. Бодит хөрөнгө оруулалт болохгүй төсөл, арга хэмжээг ОНХС-аас санхүүжүүлэх хандлага арилаагүй байна.
3. ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнг аймаг, сумын түвшинд тооцоогүй байна.

В. СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ТАЛААР

1. СХС-ийн орлогын эх үүсвэрийг батлуулаагүй, авлагын үлдэгдлийг тулган баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд зөрүүтэй тайлагнаж байна.
2. СХС-ийн журамд нийцээгүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байгаагаас сумдад жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн үндсэн зорилго биелэгдэхгүй байна.
3. СХС-ийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжоогүй, зээлдэгчдийн үйл ажиллагаанд тавих хяналт сулаас сангийн зээлийг зориулалт бусаар ашиглах, зээлийг хугацаанд нь эргэн төлүүлэх талаар хангалтгүй ажиллаж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг дарга Н.Ганбямба-д

1. ОНХС-ийн хөрөнгөөр хийх төсөл, арга хэмжээг эрэмбэлэх ажлыг чанартай үр дүнтэй зохион байгуулах талаар сумдын ажлын хэсэгт зөвлөгөө өгч, төлөвлөлтөд баримтлах зарчмуудыг зөрчсөн төсөл, арга хэмжээг батлуулахгүй байх
2. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг, тохижилт, цэцэрлэгжүүлэлт, хог цэвэрлэх, нутаг дэвсгэрийн байгаль орчинг хамгаалах, сумын бэлчээрийн нөхцөл байдлыг сайжруулах зэрэг холбогдох нарийн мэргэшил шаардахгүй 20.0 сая төгрөг хүртэлх төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2016 оны 39 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-ын дагуу зохион байгуулах,
3. ОНХС-ийн хэрэгжилтийг сум бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч, гарсан алдаа дутагдлыг засаж залруулах шаардлагатай арга хэмжээг авч ажиллах.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албын О.Алтантуяад

1. ОНХС-аас санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд тавих хяналтыг улирал тутамд зохион байгуулж, гарч буй алдаа дутагдлыг тухай бүр засуулах арга хэмжээг авч, хэрэгжүүлэх

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Энх-Амгаланд:

1. Аймгийн хэмжээнд зээлийн мэдээллийн сан бүрдүүлэх, авлагыг тулган баталгаажуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах,





2. Аймгийн хэмжээнд СХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, тайланг аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж байх,
2. СХС-ийн мэргэжилтнүүдэд зориулсан сургалтыг зохион байгуулах, чадавхижуулах, ард иргэдэд мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулах,

Сумдын Засаг дарга нарт:

- СХС-ийн эх үүсвэрийг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулах, авлагын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнахгүй байх,
- СХС-ийн журамд нийцсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх,
- Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлээр бүртгэгдсэн зээлийг барагдуулах ажлыг зохион байгуулах,
- Сангийн зээл олголт, төсөл арга хэмжээний үйл ажиллагаа, эргэн төлөлтийн талаар иргэд, олон нийтэд мэдээлж байх,
- Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд байнгын хяналт тавих хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах,
-
- ОНХС-аас санхүүжих төсөл, арга хэмжээ нь Засаг даргын мөрийн хөтөлбөртэй уялдаж байхаас гадна тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан байх шаардлагатай.
- Иргэдийн саналаар дэмжигдээгүй ч “Төсвийн тухай” хуулийн 60.11 дэх заалтад хамаарах үйлчилгээний зардлуудын хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон байх
- ОНХС-аас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сумын ИТХ-аар хэлэлцүүлэхийн өмнө ТЭЗҮ, зураг, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар зэрэг төсвийг тооцож болох баримт бичгүүдийг баталгаажуулсан байх.
- Орон нутгийн төсвийн бус байгууллага, иргэдэд тусламж, дэмжлэг, урсгал болон хөрөнгө оруулалтын чиглэлтэй төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхгүй байх.
- “ОНХС-ийн заавар”-ын 9 дүгээр зүйлд заасан хяналтуудыг хагас жил тутамд хийж, үр дүнг Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэн, гарсан алдаа дутагдалыг тухай бүр арилгах арга хэмжээ авч байх.

Аудитын тайланд дурдсан зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр хийгдсэн ажил, үр дүнгийн талаарх мэдээллийг 2019 оны 6 дугаар сарын 15-ны дотор албан бичгээр Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ.

ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛ БА ТАЙЛБАР

Ирүүлсэн албан тоот	Тайлбар
 <p style="text-align: center;">  ХЭНТИЙ АЙМАГ ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР </p> <p style="text-align: right;">Г ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</p> <p style="text-align: center;">23123 Чингис хот, Харлан сум Утас: 70-56-25-38</p> <p style="text-align: center;">2018.11.29 № 440 танай 2018.11.28 -ны № 131 -т</p> <p>Г Санал хүргүүлэх тухай Г</p> <p>Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хийгдсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Дээрх төсөлд Сумдын Засаг дарга нарт хүргүүлэх зөвлөмжид дараах саналуудыг нэмэлтээр тусгуулах саналтай байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Сум хөгжүүлэх сангийн дансыг журамд заасны дагуу ашиглаж, өөр төрлийн орлого, зарлагын гүйлгээ хийхгүй байх. 2. Сум хөгжүүлэх сангийн мэргэжилтнүүдийг чадавхижуулахад анхаарч, үүрэг хариуцлагыг нь өндөржүүлэх. 3. Дадал, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал, Жаргалтхаан, Баянхутаг, Баян-Овоо зэрэг сумдад төрийн сангийн мэргэжилтэн, нийгмийн бодлогын түшмэл, сум хөгжүүлэх сангийн асуудлыг хариуцаж байгаа нь зээлдэгчид болон тус байгууллагатай уялдаа холбоо муу байна. 4. Тус сангийн зээлд хамрагдахыг хүссэн иргэн, аж ахуй нэгжээс бусад банк, банк бус санхүүгийн байгууллагаас зээлтэй эсэх талаар лавлагаа гаргуулах. <p style="text-align: center;"> ДАРГА  Ж. ЭНХ-АМГАЛАН  </p> <p style="text-align: left;"> <i>Д. Доржпүрэв</i> <i>13.11.2018</i> <i>Санааг хариуцаж чух</i> <i>2018.11.29</i> </p>	<p>1. Тайлангийн зөвлөмжид оруулах санал нь тусгагдсан тул тайланд өөрчлөлт ороогүй</p>

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ШИЙДВЭР



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 11 дугаар сарын 30

Дугаар А/33

Чингис хот

Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/146 дугаар тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалт, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдах Зөвлөлийн 2018 оны 11 тоот хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн”- д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг audit.mn сайтад бүрэн эхээр нь байршуулан, УАГ-ын Нийцлийн аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс хөдөө аж ахуйн газарт тус тус хүргүүлсүгэй.
3. Нийцлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг нийцлийн аудитын багийн ахлах аудитор /Н.Туяа/-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

1200153